**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/041/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас:315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 315558 Цахим хаяг: gantugsss@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Мөнхбаяр<br>Утас:70110090 Цахим хаяг:audit@azure.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 512

танай ______ -ны № ______ -т

"АСГАТ" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.НАРМӨНХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Асгат ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Тайлант онд 8.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч гүйцэтгэлээр 2.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Баянгол дүүргийн төрийн өмчийн 41 цэцэрлэг, 17 сургууль, нийт 58 байгууллагад захиалгын дагуу хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан, баталгаажсан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 100%-ийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 16,306,983.57 | 134,949,034.29 |
| 1.1.2 | Дансны авлага | 25,110,750 | 72,734,723.65 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ын авлага | 167,670.40 | 439,150.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 11,644,592.31 | 14,226,297.33 |
| 1.1.6 | Бараа материал | 84,877,642.49 | 81,166,268.50 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 19,350,956.37 | - |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **157,458,595.14** | **303,515,473.77** |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 274,315,346.75 | 241,609,123.62 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 110,588,833.00 | 108,348,598.81 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **384,904,179.75** | **349,957,722.43** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **542,362,774.89** | **653,473,196.20** |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 187,247,415.64 | 237,970,798.27 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | **-** | 2,483,628.69 |
| 2.1.1.3 | Татварын өр | 53,797,411.46 | 115,518,184.90 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 6,289,005.12 | **-** |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **247,333,832.22** | **355,972,611.86** |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | - | - |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **247,333,832.22** | **355,972,611.86** |
| 2.3 | Эздийн өмч | 351,307,118.00 | 351,307,118.00 |
| 2.3.1 | Өмч: - Төрийн | 351,307,118.00 | 351,307,118.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 60,394,000.00 | 60,394,000.00 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 108,576,000.00 | 108,576,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (225,248,175.33) | (225,248,175.33) |
| 2.3.10 | Тайлант үеийн үр дүн | - | 2,471,641.67 |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **295,028,942.67** | **297,500,584.34** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **542,362,774.89** | **653,473,196.20** |

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **4,524,773,285.65** | **4,187,906,408.77** |
| 2 | Борлуулалтын өртөг | 3,784,029,392.44 | 3,259,894,753.83 |
| 3 | **Нийт ашиг (алдагдал)** | **740,743,893.21** | **928,011,654.94** |
| 4 | Түрээсийн орлого | 2,772,727.27 | - |
| 5 | Хүүгийн орлого | 1,111,055.63 | 1,158,160.03 |
| 8 | Бусад орлого | 1,922,727.27 | 6,078,352.16 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 462,333,661.73 | 36,017,994.47 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 425,684,447.49 | 876,861,084.14 |
| 11 | Санхүүгийн зардал | - | 18,422,820.00 |
| 12 | Бусад зардал | 49,185,322.49 | 1,200,000.00 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | (15,928,718.00) | **-** |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(206,581,746.33)** | **2,746,268.52** |
| 19 | Орлогын татварын зардал | 111,105.56 | 274,626.85 |
| 20 | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(206,692,851.89)** | **2,471,641.67** |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (206,692,851.89) | 2,471,641.67 |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **351,307,118.00** | **60,394,000.00** | **108,576,000.00** | **(18,555,323.44)** | **501,721,794.55** |
| Тайлант үеийн цэвэр алдагдал | - | - | - | (206,692,851.89) | (206,692,851.89) |
| **2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **351,307,118.00** | **60,394,000.00** | **108,576,000.00** | **(225,248,175.33)** | **108,576,000.00** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | 2,471,641.67 | 2,471,641.67 |
| **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **351,307,118.00** | **60,394,000.00** | **108,576,000.00** | **(222,776,533.66)** | **297,500,584.34** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 4,953,319,180.40 | 4,371,353,118.14 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 4,945,176,450.40 | 4,359,574,600.11 |
| | Бусад мөнгөн орлого | 8,142,730.00 | 11,778,518.03 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 5,160,772,879.29 | 4,237,562,928.29 |
| | Ажиллагчдад төлсөн | 532,677,795.70 | 496,181,449.86 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 151,196,050.64 | 148,629,780.72 |
| | Бараа материал худалдаж авахад төлсөн | 4,147,398,555.50 | 3,331,344,899.73 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 10,933,124.36 | 102,642,355.81 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 11,555,000.00 | 11,721,300.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 243,053,778.00 | 82,635,878.01 |
| | Хүүгийн төлбөрт төлсөн | - | 89,651.22 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | - | 372,924.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 63,958,575.09 | 63,944,688.94 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(207,453,698.89)** | **133,790,189.85** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 82,233,084.01 | 25,080.87 |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 81,233,133.94 | - |
| | Хүлээн авсан хүүгийн орлого | 999,950.07 | 25,080.87 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 90,058,501.90 | 15,173,220.00 |
| | Үндсэн хөрөнгө олз эзэмшихэд төлсөн | 17,984,900.00 | 15,173,220.00 |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 72,073,601.90 | - |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(7,825,417.89)** | **-** |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 2,025,708.00 | - |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 2,025,708.00 | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 56,161,071.42 | - |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 2,690,574.00 | - |
| | Төлсөн ногдол ашиг | 53,470,497.42 | - |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(54,135,363.42)** | **-** |
| 4 | **Бүх цэвэр мөнгөн дүн** | **(269,414,480.20)** | **118,642,050.72** |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **285,721,463.77** | **16,306,983.57** |
| 6 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **16,306,983.57** | **134,949,034.29** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */мянган төгрөгөөр/*

| Эдийн засгийн үзүүлэлт | 2024 он | 2025 он | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| Борлуулалтын орлого | 4,524,773.3 | 4,487,585.8 | 4,606,697.0 | 119,111.2 | 102.7 |
| Бусад | 1,549.2 | 6,500.0 | 7,236.5 | 736.5 | 111.3 |
| **Нийт орлогын дүн** | 4,526,322.5 | 4,494,085.8 | 4,613,933.6 | 119,847.8 | 214.0 |
| ББӨ | 3,781,478.3 | 3,316,940.2 | 3,639,590.1 | 322,649.9 | 109.7 |
| Цалин | 669,064.5 | 776,652.4 | 611,415.8 | (165,236.6) | 78.7 |
| Нийгмийн даатгал | 82,114.6 | 107,249.2 | 73,810.4 | (33,438.7) | 68.8 |
| Шуудан холбоо | 2,875.4 | 3,200.0 | 1,611.9 | (1,588.1) | 50.4 |
| Шатахуун | 8,919.9 | 12,500.0 | 12,210.0 | (290.0) | 97.7 |
| Хангамжийн материал | 5,177.2 | 7,500.0 | 7,377.3 | (122.7) | 98.4 |
| Бичиг хэрэг | 4,510.9 | 5,000.0 | 3,772.0 | (1,228.0) | 75.4 |
| Ашиглалтын зардал | 14,078.0 | 18,000.0 | 16,500.8 | (1,499.2) | 91.7 |
| Хөдөлмөр хамгаалал | 4,851.2 | 6,000.0 | 5,148.2 | (851.8) | 85.8 |
| Засварын зардал | 6,774.7 | 15,000.0 | 14,833.9 | (166.1) | 98.9 |
| Бусад зардал | 22,073.4 | 25,000.0 | 24,140.6 | (859.4) | 96.6 |
| Харуул хамгаалал | 17,480.0 | 15,000.0 | 14,080.0 | (920.0) | 93.9 |
| Элэгдлийн зардал | 30,786.4 | 32,000.0 | 77,790.9 | 45,790.9 | 243.1 |
| Түрээс | 19,800.0 | 35,000.0 | 34,800.0 | (200.0) | 99.4 |
| Сэлбэг хэрэгсэл | 2,860.1 | 16,475.0 | 16,210.8 | (264.2) | 98.4 |
| Сургалтын зардал | 10,410.5 | 20,000.0 | 9,485.0 | (10,515.0) | 47.4 |
| Албан томилолт | - | 12,000.0 | - | (12,000.0) | - |
| Татварын зардал | 709.6 | 4,000.0 | 5,616.2 | 1,616.2 | 140.4 |
| Үндсэн хөрөнгө данснаас гарсны гарз | 15,928.7 | 16,000.0 | 23,170.5 | 7,170.5 | 144.8 |
| Тээврийн зардал | 1,636.4 | 5,000.0 | - | (5,000.0) | - |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | 4,701,529.8 | 4,448,516.8 | 4,591,564.5 | 143,047.7 | 1,819.5 |
| Үйл ажиллагааны бус зардал | 28,061.8 | 26,000.0 | 19,622.8 | (6,377.2) | 75.5 |
| **Үйл ажиллагааны бус зардлын дүн** | 28,061.8 | 26,000.0 | 19,622.8 | (6,377.2) | 75.5 |
| **Нийт зардлын дүн** | 4,729,591.6 | 4,474,516.8 | 4,611,187.3 | 136,670.5 | 1,895.0 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг | (203,269.10) | 19,569.03 | 2,746.27 | (16,822.76) | - |
| Орлогын татварын зардал | 107.90 | 10,815.64 | 274.62 | (10,541.02) | - |
| Цэвэр ашиг | (203,377.00) | 8,753.39 | 2,471.65 | (6,281.74) | - |
| Үндсэн хөрөнгө худалдан авах зардал | 50,000.00 | 50,000.00 | 51,669.42 | (4,259.28) | - |
| Орлогын 1 төгрөгт ногдох зардал | 0.96 | 0.99 | 1.00 | - | - |
| Хөрөнгө оруулалт | 40,540.00 | 60,000.00 | - | - | - |

## Гурав. Аудитын илрүүлэлт:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитаар нийт 127,806.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд 127,806.0 мянган төгрөгийн дүн бүхий 8 хөрөнгийг коджуулаагүй байна. | 1 | 127,806.0 | 1 | 127,806.0 | - | - | 1 | 127,806.0 | - | - | - | - |
| | **Дүн** | **1** | **127,806.0** | **1** | **127,806.0** | **-** | **-** | **1** | **127,806.0** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 15,825.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд, 487.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12,745.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2,593.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Цалин хөлсний цагийн бүртгэлд бүртгэгдээгүй ажилтанд илүү цагийн хөлс олгосон байна. | 1 | 487.8 | 1 | 487.8 | - | - | - | - | - | - | - | - |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Тайлант хугацааны эцсээрх авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 12,745.1 | - | - | 1 | 12,745.1 | - | - | - | - | - | - |
| 3 | Шалгагдагч этгээд нь 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр төрийн аудитын байгууллагад санхүүгийн тайлангаа хүргүүлсэн байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| 4 | Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 17,559.8 мянган төгрөгийн 17 хөрөнгийн ашиглалтын хугацаа, үлдэх өртгийн шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| 5 | Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 8 ширхэг хөрөнгийг бүртгэсэн байна. | 1 | 2,593.0 | - | - | - | - | 1 | 2,593.0 | - | - | - | - |
| | **Дүн** | **5** | **15,825.9** | **1** | **487.8** | **2** | **12,745.1** | **2** | **2,593.0** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 2 зөрчил[3] илэрснээс 2 албан шаардлага хүргүүлсэн.

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хууль** | | | | | | | | |
| Тус байгууллага нь байршуулбал зохих 169 мэдээллээс Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) гэсэн мэдээллийг 1,3,5,6,7,11 саруудад, хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн нийт 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **Төрийн хэмнэлтийн тухай хууль** | | | | | | | | |
| Тайланд хугацаанд худалдан авсан 11,545.5 мянган төгрөгийн дэлгэц, таблет, принтер, компьютерийг цахим дэлгүүрээс аваагүй байна. | 1 | 11,545.5 | | | 1 | 11,545.5 | | |
| 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн зөвлөх үйлчилгээний төлбөрт 3,000.0 мянган төгрөг, нягтлан бодогчид олгосон 2,218.3 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, мөн Хөдөлмөрийн дотоод журмын 9.2.4 "Ажилтан албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэж буй ур чадвар, идэвхи санаачлагыг үнэлэн жилд 1-3 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг захирлын шийдвэрээр олгож болно" гэсэн заалтаар олгосон урамшуулал нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй байна. | 1 | 9,192.7 | | | 1 | 9,192.7 | | |
| **Дүн** | **3** | **20,738.2** | - | - | **1** | **20,738.2** | - | - |

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.